



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 21 өдөр

Дугаар А/653

Хэрлэн сум

Сургалтад хөрөнгө
зарцуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны "Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" 06 дугаар тогтоол, 2023 оны 18 дугаар хуралдааны "Аймгийн 2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай" 02 дугаар тогтоолын 06 дугаар хавсралт, Сангын Сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төрийн албан хаагчдын хэрэгцээ шаардлагад үндэслэн "Танхимын болон цахим сургалт"-ын нэгдсэн арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж түвшин тогтоох ажлын дагуу сумдын Засаг даргын Тамгын газар, тосгодын Захирагчийн ажлын албаны ажилчдад зориулсан "Байгууллагын соёл, багаар ажиллах ур чадвар, манлайлах ур чадвар" сэдэвт сургалт, арга хэмжээнд зориулж 4,453,000 (дөрвөн сая дөрвөн зуун тавин гурван мянга) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.


2.Сургалт арга хэмжээнд шаардагдах зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн тухайн төсвийн жилийн явцад шинээр бавлагдсан хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэхэд шаардагдах нэмэлт зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 21-ны дугаар захирамжийн хавсралт

ЗАРДЛЫН ТООЦОО

Д/д	Зардлын төрөл	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ
1	Сургалтын үдийн цайны зардал (сендвич, кофе)	1	4.453.000